



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Хаврын техникийн үзлэг, оношилгоо
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Автотээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Засгийн газрын 2016 оны “Автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах давтамж, оношилгооны төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 213 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын “Дүрэм”-ийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний их, дунд, бага багтаамжийн автобус, троллейбус, ажилчдын автобус болон такси үйлчилгээний тээврийн хэрэгслийн хаврын техникийн үзлэг, оношилгоог 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрийг дуусталх хугацаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцүүлэн шуурхай зохион байгуулж, Захиргааны зөвлөлийн хуралд 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн дотор танилцуулах, холбогдох байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллахыг Техникийн үзлэг, оношилгооны төв /Ц.Нанжид/-д даалгасугай.

2. Тушаалаар батлагдсан хугацаанд үзлэгт хамрагдаагүй болон тэнцээгүй тээврийн хэрэгслүүдийн мэдээллийг Улаанбаатар смарт карт ХХК-ийн Тbox програмд тухай бүрт нь оруулах, тэнцээгүй тээврийн хэрэгслийг тухайн өдөрт нь давтан оруулахгүй байх, үзлэгийн дүн мэдээг холбогдох байгууллага хэлтсүүдэд шуурхай, үнэн зөв хүргүүлж ажиллахыг Техникийн үзлэг, оношилгооны төв /Ц.Нанжид/-д даалгасугай.

3. Техникийн үзлэг, оношилгооны төвийн тоног төхөөрөмжийн үзлэг урсгал засварын зардал 1,848,000 /нэг сая найман зуун дөчин найман мянга/ төгрөгийг гаргахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн ахлах нягтлан бодогч /Э.Эрдэнэтуяа/- д зөвшөөрсүгэй.

4. Хаврын техникийн хяналтын үзлэгт, оношилгоонд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх гэрээтэй аж ахуйн нэгж, байгууллагууд тээврийн хэрэгслүүдийг баталсан хуваарийн дагуу жигд, шуурхай хамруулах талаар шаардлага хүргүүлэн хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /Ц.Мягмар/-т үүрэг болгосугай.

5. Нийтийн тээврийн бүртгэлийн санд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг тушаалаар батлагдсан хуваарьт хугацаанд багтаан холбогдох стандартын шаардлагуудыг бүрэн хангуулж, тээврийн хэрэгслийн өнгө үзэмж, цэвэрлэгээ, иж бүрдэл, замналын нэр, хаяг, зураглал, дугаар зэрэг нэмэлт шаардлагуудыг онцгой анхаарч техникийн хяналтын үзлэгт жигд, шуурхай хамруулахыг тус газартай нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулан ажиллаж байгаа нийт аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ОТГОНБААТАР